



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 2/140

Арвайхээр сум

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны өрөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Музейн тоног төхөөрөмж (Өвөрхангай, Арвайхээр сум) нийлүүлэх тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Пүрэвсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Ц.Болдбаатар (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Ц.Соёлбадрах (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Б.Уганбаяр (Өвөрхангай аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга) (зөвшилцсөнөөр)

Нарийн бичиг:

Т.Эрдэнэсүрэн (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа, дотоод хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Б.Пүрэвсүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

И.ДОРЖСҮРЭН

6224 11 0282